

**БАЯНТҮМЭН СУМЫН ЕБСУРГУУЛИЙН 7 ДУГААР АНГИЙН СУРАГЧДЫН  
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

Хугацаа: 60 минут

А вариант

Нийт 20 оноо

С.Эрдэнэ

**Аян замын тэмдэглэлээс...**

Дадал уулынхаа барааг хараад, хамар шархирч дуугүй болов. Одоогоос тавин гурван жилийн өмнө юм сан. Би тэгэхэд ямархан амьтан явлаа даа. Бууралхан Дадал минь буцаж л тандаа ирлээ дээ. Ар бэлээр нь Тэнгэлиг горхин урсдагаараа л урсаж байна. Харин Дадал улам өвгөрчээ. Бургас торлогт хучигдаж, ганга жалганд идэгдэж, үрчийж арчийж орхижээ хөөрхий. Ер энэ Дадал уулын ар хормой Тэнгэлиг горхины хотгор хүрэн хөндийн салхи гагцхүү өнгөрч улирсан холын он жилүүдийг шивнэнэ. Тэр холын ийм л хавраар нөмөрт нь сууж Дадал уулын оройг ширтэн ганцаар санааширдаг асан бага сургуулийн минь дүнзэн байшингийн буурьт шарилж өвс урган эдгэрч, хуучин сумын төвийн барилга байшин, айлуудын хашаа хороо хаана юу байсан нь нэгэнт мартагдан, одоо хаваржиж буй ганц хоёр айлын ядуухан дүр зураг уйтгар төрүүлнэ. Жаргалтай ч бага нас минь гэхэд тиймхэн тэр холхийн холхи хавраар очиж хичээлээ давтдаг асан Шувуутын энгэрийн боржин хад минь даанч танил. Хад чулуу боловч эрт өнгөрсөн хайрт хүнтэйгээ дахин гэнэт уулзах адил нүдний нулимс бүрхүүлээд байхыг яанам билээ.

Хадны завсраас залуухан цагаан хус ургажээ. Бага нас чамайгаа тэврэн уйлнам. Тэр цагаахан хусанд цэнхэр хадаг зүүж таалав би. Дурдатгалаар амьдрах цаг иржээ.

Цагаахан хусхан цэцэг ургуулсан хадных нь нөмөрт тавин гурван жилийн дараах хавар ирээд сууж байнам. Дадал уулын оройгоор харж суухад тавин гурван жилийн түмэн зургууд нүдний өмнүүр жирэлзэнэ.

**Ажиллах даалгавар:**

1. Эхэд нутаг орны дүр байдлын гадаад шинж, би баатрын дотоод шинжийг илэрхийлсэн үг, хэллэгээс 1, 1 жишээгээр батлан бичээрэй. /2 оноо/

1. Гадаад шинж:	
2. Дотоод шинж:	

2. “Тэнгэлиг горхин урсав.

Хадны завсраас залуухан цагаан хус ургажээ” 2 өгүүлбэрийг зэрэгцүүлэн холбох үгээр хэлбэржүүлэн ЗНӨ болгоорой.

/2 оноо/

.....

.....

.....

.....

3. Аль нь зэрэгцсэн нийлмэл үг вэ?

/2 оноо/

а. Нүдний нулимс      б. Цэнхэр хадаг      в. хад минь

4. Бургас торлогт хучигдаж, ганга жалганд **идэгдэж**, үрчийж арчийж орхижээ хөөрхий.” Тодруулсан үгийг үгийн бүтцээр зөв задалсныг дугуйлаарай. /2 оноо/

а. Ид+гд+ж                      б. ид+гд+0+ж                      в. ид+0+гд+ж                      г. ид+0+гд+0+ж

5. Эхээс зөв бичгийн дүрмээр бичсэн үгсийн жишээ нэгийг олж бичнэ үү. /2 оноо/

Зөв бичгийн дүрэм	Эхээс тохирох жишээ	Зөв бичгийн дүрмийн тайлбар
Балархай эгшгийг гэж бичсэн		

6. П.Пүрэвсайхан “Бурханбогд аав хоёр” өгүүллэгт “... өмнөх байшин, одоогийн амьдарч байгаа байшин хоёрыг хэрхэн дүрсэлснийг харьцуулаад зохиолч үүгээр юуг тодотгож, ямар санаа гаргасныг тайлбарлаарай. /5оноо/

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

7. Галигаас үндэсний бичигт хөрвүүлээрэй. /5 оноо/

Монгулчуд эртэ дэгэр-э үй-э-дү хураг-а-бан голугсан хонин-ду хураг-а-йи ни абхугулху-йин тулада энэ хөгжим-и бүтүгэгсэн тэхэ-тэй. Эймү учир-ача хураган чихи хэмэн нэрэлэжэй.

.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------

Даалгавар гүйцэтгэсэн  
Сурагч .....

## Хариу

## Аян замын тэмдэглэлээс...

№	Асуулт даалгавар	Зөв хариулт	Оноо	Тайлбар
1.	Дээрх эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг тодорхойлоорой.	в	2	□ Хариулт оновчгүй бол 0 оноо Жич: Зөв хариултыг өөрийн үгээр юм уу, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол зохих оноог өгнө
2.	Эхэд нутаг орны дүр байдлын гадаад шинж, би баатрын дотоод шинжийг илэрхийлсэн үг, уран дүрслэлийг 1, 1жишээгээр батлан бичээрэй.	<b>Дотоод шинж:</b> Дадал уулынхаа барааг хараад, хамар шархирч дуугүй болов. Хад чулуу боловч эрт өнгөрсөн хайрт хүнтэйгээ дахин гэнэт уулзах адил нудний нулимс бүрхүүлээд байхыг яанам билээ. Бага нас чамайгаа тэврэн уйлнам. Ядуухан дүр зураг уйтгар төрүүлнэ. <b>Уран дүрслэл:</b> Дадал улам өвгөрчээ. Салхи гагцхүү өнгөрч улирсан холын он жилүүдийг шивнэнэ. <b>Гадаад шинж:</b> Бургас торлогт хучигдаж, ганга жалганд идэгдэж, үрчийж арчийж орхижээ хөөрхий. боржин хад минь даанч танил, Цагаахан хусхан цэцэг ургуулсан хадных нь гэх мэт	4	
3.	“ урс+на=? -на <sup>4</sup> нөхцөлийг залгах зөв бичгийн дүрмийг тайлбарлана уу.	Урсана- Дараалсан 3 гийгүүлэгчийн Здахь нь хэлний үзүүрийн -н байвал урдаа эгшиг авна.	1	
4.	Эхээс зөв бичгийн дүрмээр бичсэн үгсийн жишээ нэгийг олж бичнэ үү.	хавар+аар= хавраар, зургууд, завсраар Дүрэм: Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгахав балархай эгшгийг гээнэ. Хайчил+н	1	
5.	Тодруулсан үг, өгүүлбэрийн утга, уран дүрслэлийг тайлбарлаарай.	<b>“ Салхи он жилүүдийг шивнэнэ –</b> хүншүүлэл, уран дүрслэл <b>үрчийж арчийж-</b> дүрслэх үг, дүр байдлыг дүрсэлсэн	1	
6.	“Бургас торлогт хучигдаж, ганга жалганд идэгджээ.” 2 өгүүлбэрийг холбосон арга, хэрэглүүрийг тайлбарлаарай.	Ж- нөхцөлийн арга, зэрэгцэн холбох нөхцөл	1	
7.	2 өгүүлбэрийг зэрэгцүүлэн холбох үгээр хэлбэржүүлэн ЗНӨ болгоорой.	“Тэнгэлиг горхин урсах <b>бөгөөд</b> хадны завсраас залуухан цагаан хус ургажээ” Ба, буюу, агаад, хийгээд г.м	1	
8.	Кириллээс үндэсний бичгээр бичээрэй.	20 үг	5	1 үг 0,25 оноо
9.	Үгсийг уншаад хэлбэр дүрс заасан тэмдэг нэрийг олоорой.	В	1	1 үг 0,1 оноо
10.	Гадаад үгийг уншаад, зөвийг сонгоорой.	б	1	
11.	Урт эгшигтэй үгийн бүтцийг зөв тодорхойлсон нь аль вэ?	б	1	
12.	Гийгүүлэгчээр төгссөн үйл үгийн үндсэнд шууд залгах нөхцөлийг ялгана уу.	а		
13.	“Миний нар” сэдвээр гадаад, дотоод шинж, сонин содон дүрслэлийг ашиглан хөрөг бичнэ үү. Үгийн тоо 100-120	Эхийн бүтэц, уялдаа холбоо- эхлэл, гол, төгсгөл хэсэг нь дараалалтай, догол мөртэй байх – 3 оноо Баримт, дүрслэл- 2 оноо Найруулга – 2 оноо Зөв бичих дүрэм – 1 оноо	8	

**БАЯНТҮМЭН СУМЫН ЕБСУРГУУЛИЙН 7 ДУГААР АНГИЙН СУРАГЧДЫН  
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

Хугацаа: 60 минут

Б вариант

Нийт 20 оноо

Д.Батбаяр

**Хавар**

Модод навчилж, гол урсаж, урь унахаар  
Монгол нутгаа санах минь даанч их ээ...

Гол горхи хүсэл мэт тэмүүлэн урсана. Цэцэг ногоо бодол мэт чимээгүй ургана. Тунгалаг гэрэл, ариун үнэр арван зүгт дэлгэрнэ. Дуу чимээ алслан түгж, цэнхэр, ногоон хоёр өнгө хослон жигдэрнэ. Салхи урьхнаар мяралзан ирж, уйтгарыг аван одно.

Хүний зүрхэнд баяр гийж, хүлгийн туурайнаас ногоо ханхлахад хэрээ хүртэл сөөнгө хоолойгоор хаврын дуу дуулна.

Гэтэл гэнэт яав, юу болов гэмээр салхи догшрон ирж, согтуу хүн шиг хаалга цонх балбана. Хөрст дэлхий хөх тэнгэрт гарчхав уу гэмээр орчлон ертөнц булингартан эргэлдэж, од гараг мөргөлдөн унах шиг болно. Тэгснээ орой тийшээ яагаа ч үгүй юм шиг нам гүм, урьдынхаасаа гойд сайхан шөнө болно.

Эргэн тойрон цэцэг, ургамал ногоо дэлгэрч байгаа юм шиг нам гүм байтал дахиад л галуу ганганана... Хавар би аз жаргалтай гэж өөрийгөө бодно. Хаврын тэнгэр голдуу л хүүхдийн нүд шиг тунгалаг байна. Цагийн цагт тэнгэр хүүхдийн нүд шиг байгаасай гэж би хавар улам ихээр хүснэ.

**Ажиллах даалгавар:**

1. Эхэд нутаг орны дүр байдлын гадаад шинж, би баатрын дотоод шинжийг илэрхийлсэн үг, хэллэгээс 1, 1 жишээгээр батлан бичээрэй.  
/2оноо/

Гадаад шинж:	
Дотоод шинж:	

2. “Модод навчилна.  
Гол урсана.” 2 өгүүлбэрийг зэрэгцүүлэн холбох үгээр хэлбэржүүлэн 3НӨ болгоорой.  
/2 оноо/  
.....  
.....  
.....
3. Аль нь зэрэгцсэн нийлмэл үг вэ? /2 оноо/  
а. Хүүхдийн нүд      б. Аз жаргал      в. нүд шиг тунгалаг
4. “Хавар би аз жаргалтай гэж өөрийгөө **бодно**.” тодруулсан үгийг үгийн бүтцээр зөв задалсныг дугуйлаарай. /2 оноо/  
а. Бод+0+но      б. Бод+0+0+но      в. бод+но

5. Эхээс зөв бичгийн дүрмээр бичсэн үгсийн жишээ нэгийг олж бичнэ үү. /1 оноо/

Зөв бичгийн дүрэм	Эхээс тохирох жишээ	Зөв бичгийн дүрмийн тайлбар
Балархай эгшгийг гэж бичсэн		

6. Б.Ренчин “Шүхэрч Буниа” өгүүллэгт Урьдын цагт ард түмний ухаантай сэргэлэн хүүхдүүд билиг авьяасаа хөгжүүлж чадахгүй хувь заяа, амь нас нь хохирч байсныг харуулсныг зохиолын үйл явдлаар баталж тайлбарлаарай. /5 оноо/

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

7. Галигаас үндэсний бичигт хөрвүүлээрэй. /5 оноо/  
Мину хуби-ду эрхим-эчэ эрхим хорва-ду гагчахан удаг-а зайагад эргигэд абчу болдаг үгэи, худалдужу абчу болдаг үгэи эрдэни бол эхэ сайихан орун мини йум.

.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------

## Хариу

## Хавар

№	Асуулт даалгавар	Зөв хариулт	Оноо	Тайлбар
1.	Дээрх эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг тодорхойлоорой.	б	2	□ Хариулт оновчгүй бол 0 оноо Жич: Зөв хариултыг өөрийн үгээр юм уу, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол зохих оноог өгнө
2.	Эхэд нутаг орны дүр байдлын гадаад шинж, би баатрын дотоод шинжийг илэрхийлсэн үг, уран дүрслэлийг 1, 1жишээгээр батлан бичээрэй.	<b>Дотоод шинж:</b> Хүний зүрхэнд баяр гийж, цагийн цагт тэнгэр хүүхдийн нүд шиг байгаасай Салхи урьхнаар мяралзан ирж, уйтгарыг аван одно. <b>Уран дүрслэл:</b> хүүхдийн нүд шиг байгаасай, хүсэл мэт, согтуу хүн шиг, бодол мэт, хэрээ хүртэл сөөнгө хоолойгоор хаврын дуу дуулна. Салхи урьхнаар мяралзан ирж, уйтгарыг аван одно, хавар аз жаргалтай гэж өөрийгөө бодно <b>Гадаад шинж:</b> Тунгалаг гэрэл, цэнхэр, ногоон хоёр өнгө хослонг гол горхи хүсэл мэт тэмүүлэн урсана. Цэцэг ногоо бодол мэт чимээгүй ургана	4	
3.	“ урс+на=? -на <sup>4</sup> нөхцөлийг залгах зөв бичгийн дүрмийг тайлбарлана уу.	давтана- Дараалсан 3 гийгүүлэгчийн Здахь нь хэлний үзүүрийн -н байвал урдаа эгшиг авна.	1	Санаагаа гүйцэд гаргаж чадсан бол 1 оноо, дутуу бол 0,5 оноо, гаргаж чадаагүй бол 0 оноо
4.	Эхээс зөв бичгийн дүрмээр бичсэн үгсийн жишээ нэгийг олж бичнэ үү.	хавар+ын= хаврын, урьхнаар, тэгснээ, хүлгийн, хүүхдийн Дүрэм: Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгахад балархай эгшгийг гээнэ. алсал+н, хосол+н, гарчих+в, догшир+н эГ+Г= гээнэ	1	
5.	Тодруулсан үг, өгүүлбэрийн утга, уран дүрслэлийг тайлбарлаарай.	<b>Салхи өөрийгөө жаргалтай гэж бодох –</b> хүншүүлэл, уран дүрслэл <b>Нам гүм-</b> чимээгүй гэсэн утгатай, дүр байдлыг дүрсэлсэн	1	
6.	“ Хүний зүрхэнд баяр гийж, хүлгийн туурайнаас ногоо ханхална.” 2 өгүүлбэрийг холбосон арга, хэрэглүүрийг тайлбарлаарай.	Ж- нөхцөлийн арга, зэрэгцэн холбох нөхцөл	1	
7.	2 өгүүлбэрийг зэрэгцүүлэн холбох үгээр хэлбэржүүлэн ЗНӨ болгоорой.	“ Модод навчлах <b>ба</b> гол урсана. Бөгөөд, буюу, агаад, хийгээд г.м	1	
8.	Кириллээс үндэсний бичгээр бичээрэй.	20 үг	5	1 үг 0,25 оноо
9.	Нэлбэр дүрс заасан тэмдэг нэрийг олоорой.	В	1	1 үг 0,1 оноо
10.	Гадаад үгийг уншаад, зөвийг сонгоорой.	б	1	
11.	Урт эгшигтэй үгийн бүтцийг зөв тодорхойлсон нь аль вэ?	а	1	
12.	Үйл үгийн үндсэнд шууд залгах нөхцөлийг ялгана уу.	г		
13.	“Миний нар” сэдвээр гадаад, дотоод шинж, сонин содон дүрслэлийг ашиглан хөрөг бичнэ үү. Үгийн тоо 100-120	Эхийн бүтэц, уялдаа холбоо- эхлэл, гол, төгсгөл хэсэг нь дараалалтай, догол мөртэй байх – 3 оноо Баримт, дүрслэл- 2 оноо Найруулга – 2 оноо Зөв бичих дүрэм – 1 оноо	8	